## Хавсралт 1

### Зээлжих зэрэглэлийн шатлал

<table>
<tr><th>Үнэлгээ</th><th>Зэрэглэл</th><th>Тайлбар</th></tr>
<tr><td>AAA</td><td rowspan="10">Хөрөнгө оруулалтын</td><td>Хамгийн бага эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын зэрэглэл</td></tr>
<tr><td>AA+</td><td rowspan="3">Маш бага эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын зэрэглэл</td></tr>
<tr><td>AA</td></tr>
<tr><td>AA-</td></tr>
<tr><td>A+</td><td rowspan="3">Эрсдэл багатай, хөрөнгө оруулалтын дундаас дээш зэрэглэл</td></tr>
<tr><td>A</td></tr>
<tr><td>A-</td></tr>
<tr><td>BBB+</td><td rowspan="3">Дунд зэргийн эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын дундаж зэрэглэл</td></tr>
<tr><td>BBB</td></tr>
<tr><td>BBB-</td></tr>
<tr><td>BB</td><td rowspan="15">Спекулятив</td><td rowspan="3">Ихээхэн эрсдэлтэй, спекулятив шинжтэй</td></tr>
<tr><td>BB+</td></tr>
<tr><td>BB-</td></tr>
<tr><td>B+</td><td rowspan="3">Өндөр эрсдэлтэй, спекулятив</td></tr>
<tr><td>B</td></tr>
<tr><td>B-</td></tr>
<tr><td>CCC+</td><td rowspan="3">Маш өндөр эрсдэлтэй, спекулятив</td></tr>
<tr><td>CCC</td></tr>
<tr><td>CCC-</td></tr>
<tr><td>CC+</td><td rowspan="3">Үндсэн төлбөр болон хүүгийн нөхөн төлбөрийг барагдуулах магадлал багатай эсвэл барагдуулах магадлал маш бага байна.</td></tr>
<tr><td>CC</td></tr>
<tr><td>CC-</td></tr>
<tr><td>C+</td><td rowspan="3">Үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх магадлал бага.</td></tr>
<tr><td>C</td></tr>
<tr><td>C-</td></tr>
<tr><td>D</td><td>Дефольт</td><td></td></tr>
</table>

**Тэмдэглэл: MIRA нь AA-аас C хүртэлх ерөнхий үнэлгээний ангилал бүрт эерэг, тогтвортой, хувьсах, сөрөг хэтийн төлөв хавсаргана. Эерэг төлөв нь тухайн шатлалын дээд ангилал; тогтвортой төлөв нь дунд ангилалд; хувьсах төлөв нь дундаас доош ангилалд; сөрөг төлөв нь доод ангилалд багтана.*

'AAA' шатлалаас 'BBB' хүртэл хөрөнгө оруулалтын зэрэглэл, 'BB' шатлалаас 'D' хүртэл спекулятив буюу хөрөнгө оруулалтын бус гэж үздэг. "Хөрөнгө оруулалтын зэрэглэл" нь зээлийн эрсдэл дунд юм уу бага байгааг илэрхийлдэг бол "спекулятив" нь зээлийн эрсдэл өндөр байгааг илэрхийлдэг.

Хөрөнгө оруулалтын зэрэглэл нь хөрөнгө оруулалтын зорилгоор үнэт цаас болон бусад өрийн хэрэгсэл худалдан авах талаар ямар нэгэн санал зөвлөмж болохгүй болно.

## Зээлжих зэрэглэлийн төлөв

MIRA компанид зээлжих зэрэглэл тогтоохдоо 1 жилийн хугацаанд тухайн тогтоосон зээлжих зэрэглэл нь аль шатлалрүү өөрчлөгдөх боломжтойг илэрхийлсэн төлөвийг (эерэг, тогтвортой, сөрөг болон хувьсах) тодорхойлно.

| **Төлөв** | **Төлөвийн тэмдэгт** |
|---|---|
| Эерэг | ✚ |
| Сөрөг | ▬ |
| Хувьсах | ● |
| Тогтвортой | ■ |